



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/01-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 7036-3040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 7036-3036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: О.Анхбаяр  
Утас: 7036-2442 Цахим хаяг: [ankhbayaro@audit.gov.mn](mailto:ankhbayaro@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа .....	19
4.2 Албан шаардлага: .....	19
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТЗ	Төрийн захиргаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТ	Улс төрийн
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/01-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 965.5 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 645.1 мянган төгрөгийн зэрэг нийт **1,610.6** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Дараах хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **14,368.7** мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:
  - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөл, хороо, комиссын гишүүд, ангилагдаагүй бусад зориулалт зэрэг

хөтөлбөрийн НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардалд **760.7** мянган төгрөг,

- ИТХ-ын хуралдааны зардалд баталсан хоолны зардлаас УИХ-ын гишүүд, сэтгүүлчдийн хоол, зочид буудлын зардалд **480.4** мянган төгрөг,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардлаас дотоодын зочин төлөөлөгч хүлээн авах зардалд **447.0** мянган төгрөг, хоолны зардалд **239.3** мянган төгрөг зэрэг нийт **686.3** мянган төгрөг,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд **438.8** мянган төгрөг,
- Баяр наадмын арга хэмжээний /Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн аяга, бал, дэвтэр гэх мэт бэлэг дурсгалын зүйл/, зардалд зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас **7,580.0** мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас **3,363.0** мянган төгрөг зэрэг нийт **10,943,0** мянган төгрөг,
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал болон хуралдааны зардлаас бусдад өгөх бэлэг гэх үндэслэлээр **531.5** мянган төгрөгийн архи, **528.0** мянган төгрөгийн / 9 сард / чихэр зэргийг худалдан авсан байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,740,556.00</b>	<b>32,393,761.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,740,556.00</b>	<b>32,393,761.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>36,740,556.00</b>	<b>32,393,761.00</b>
35410	Бичиг хэргийн материал	8,190,200.00	18,086,930.00
35420	Аж ахуйн материал	20,559,750.00	13,125,950.00
35440	Түлш, шатах тослох материал	7,990,606.00	1,145,881.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	35,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>64,458,304.83</b>	<b>39,364,375.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>64,458,304.83</b>	<b>39,364,375.97</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>64,458,304.83</b>	<b>39,364,375.97</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,800,000.00	126,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-118,049,999.90	-120,549,999.86
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	87,377,080.00	92,124,480.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,842,810.82	-75,251,089.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,405,115.20	23,405,115.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,231,079.65	-7,164,129.65
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>101,198,860.83</b>	<b>71,758,136.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>491,838.00</b>	<b>1,610,629.54</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>491,838.00</b>	<b>1,610,629.54</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>491,838.00</b>	<b>1,610,629.54</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	491,838.00	1,610,629.54
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>100,707,022.83</b>	<b>70,147,507.43</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>100,707,022.83</b>	<b>70,147,507.43</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	99,213,204.00	99,213,204.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,493,818.83</b>	<b>-29,065,696.57</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,603,366.95	1,493,818.83
51220	Тайлант үеийн үр дүн	-5,109,548.12	-30,559,515.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>101,198,860.83</b>	<b>71,758,136.97</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,262,948,985.00</b>	<b>716,567,571.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>573,000.00</b>	<b>148,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>573,000.00</b>	<b>148,000.00</b>
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	573,000.00	148,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,262,375,985.00</b>	<b>716,419,571.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,683,514,350.00</b>	<b>139,140,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,683,000,000.00	139,140,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	514,350.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>578,861,635.00</b>	<b>577,279,571.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	578,861,635.00	577,279,571.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,268,058,533.12</b>	<b>747,127,086.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,268,058,533.12</b>	<b>747,127,086.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>402,224,603.12</b>	<b>434,634,886.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>161,302,512.55</b>	<b>164,825,166.88</b>
210101	Үндсэн цалин	97,221,124.46	94,827,118.60
210102	Нэмэгдэл	34,559,591.09	39,819,350.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,445,807.00	5,564,751.00
210104	Урамшуулал	26,075,990.00	24,613,947.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,509,203.45</b>	<b>22,761,024.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,206,803.45	16,233,824.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,575,600.00	1,631,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,500.00	1,305,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	315,100.00	326,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,151,200.00	3,263,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,288,664.00</b>	<b>72,768,195.00</b>
210401	Бичиг хэрэг	8,745,200.00	17,350,370.00
210402	Тээвэр, шатахуун	22,713,159.00	22,549,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,739,400.00	2,096,434.00
210404	Ном, хэвлэл	72,000.00	1,040,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,818,905.00	23,919,866.00
210408	Бараа материал акталсны зардал	8,200,000.00	5,811,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,938,015.00</b>	<b>14,096,500.00</b>
210502	Хоол, хүнс	8,938,015.00	14,096,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,401,500.00</b>	<b>5,758,000.00</b>
210604	Урсгал засвар	9,401,500.00	5,758,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,322,485.00</b>	<b>9,104,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,220,400.00	7,888,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,102,085.00	1,216,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>112,395,600.00</b>	<b>98,758,721.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,941,500.00	96,366,690.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00

210803	Даатгалын үйлчилгээ	1,578,000.00	1,334,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,100.00	422,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	590,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,066,623.12</b>	<b>46,563,178.86</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,900,000.00	16,721,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,166,623.12	29,841,328.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,865,833,930.00</b>	<b>312,492,200.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>180,000,000.00</b>	<b>185,000,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.00	185,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,685,833,930.00</b>	<b>127,492,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,683,000,000.00	120,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,833,930.00	7,492,200.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-5,109,548.12</b>	<b>-30,559,515.40</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-5,109,548.12</b>	<b>-30,559,515.40</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,213,204.00	0.00	6,603,366.95	105,816,570.95
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,213,204.00	0.00	6,603,366.95	105,816,570.95
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,109,548.12	-5,109,548.12
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,213,204.00	0.00	1,493,818.83	100,707,022.83
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	99,213,204.00	0.00	1,493,818.83	100,707,022.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,213,204.00	0.00	1,493,818.83	100,707,022.83
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-30,559,515.40	-30,559,515.40
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	99,213,204.00	0.00	-29,065,696.57	70,147,507.43

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,262,375,985.00</b>	<b>716,419,571.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,262,375,985.00</b>	<b>716,419,571.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,683,514,350.00</b>	<b>139,140,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,683,000,000.00	139,140,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	514,350.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>578,861,635.00</b>	<b>577,279,571.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	578,861,635.00	577,279,571.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,236,363,285.00</b>	<b>711,672,171.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,236,363,285.00</b>	<b>711,672,171.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>370,529,355.00</b>	<b>399,006,971.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>161,812,527.55</b>	<b>164,180,000.00</b>
210101	Үндсэн цалин	97,003,846.46	94,181,951.72
210102	Нэмэгдэл	34,535,206.09	39,819,350.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,563,085.00	5,564,751.00
210104	Урамшуулал	26,710,390.00	24,613,947.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,946,422.45</b>	<b>22,287,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,644,022.45	15,760,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,575,600.00	1,631,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,500.00	1,305,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	315,100.00	326,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,151,200.00	3,263,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,218,705.00</b>	<b>38,548,000.00</b>
210401	Бичиг хэрэг	2,223,000.00	4,915,600.00
210402	Тээвэр, шатахуун	23,457,400.00	11,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,739,400.00	2,096,434.00
210404	Ном, хэвлэл	72,000.00	2,948,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,726,905.00	16,887,966.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,938,015.00</b>	<b>14,474,600.00</b>
210502	Хоол, хүнс	8,938,015.00	14,474,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,401,500.00</b>	<b>5,798,000.00</b>
210604	Урсгал засвар	9,401,500.00	5,798,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,219,485.00</b>	<b>16,923,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,220,400.00	7,888,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,999,085.00	9,035,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>117,092,700.00</b>	<b>120,073,421.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,638,600.00	117,681,390.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,578,000.00	1,334,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,100.00	422,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	590,700.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,900,000.00</b>	<b>16,721,850.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,900,000.00	16,721,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,865,833,930.00</b>	<b>312,665,200.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>180,000,000.00</b>	<b>185,000,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	180,000,000.00	185,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,685,833,930.00</b>	<b>127,665,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,683,000,000.00	120,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,833,930.00	7,665,200.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>26,012,700.00</b>	<b>4,747,400.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>26,012,700.00</b>	<b>4,747,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,012,700.00</b>	<b>4,747,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>26,012,700.00</b>	<b>4,747,400.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,012,700.00	4,747,400.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-26,012,700.00</b>	<b>-4,747,400.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>590,502,400.00</b>	<b>577,279,571.00</b>	<b>-13,222,829.00</b>	<b>97.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>590,502,400.00</b>	<b>577,279,571.00</b>	<b>-13,222,829.00</b>	<b>97.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>397,837,200.00</b>	<b>384,614,371.00</b>	<b>-13,222,829.00</b>	<b>96.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>164,180,000.00</b>	<b>164,180,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210101	Үндсэн цалин	104,380,000.00	94,181,951.72	-10,198,048.28	90.23
210102	Нэмэгдэл	29,800,000.00	39,819,350.28	10,019,350.28	133.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,040,000.00	5,564,751.00	524,751.00	110.41
210104	Урамшуулал	24,960,000.00	24,613,947.00	-346,053.00	98.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,287,400.00</b>	<b>22,287,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,760,200.00	15,760,200.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,631,800.00	1,631,800.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,305,500.00	1,305,500.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	326,300.00	326,300.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,263,600.00	3,263,600.00	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,548,000.00</b>	<b>38,548,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	4,915,600.00	1,915,600.00	163.85
210402	Тээвэр, шатахуун	11,700,000.00	11,700,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,096,434.00	-303,566.00	87.35
210404	Ном, хэвлэл	2,948,000.00	2,948,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,500,000.00	16,887,966.00	-1,612,034.00	91.29
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,474,600.00</b>	<b>14,474,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	14,474,600.00	14,474,600.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,322,700.00</b>	<b>10,545,400.00</b>	<b>-2,777,300.00</b>	<b>79.15</b>

210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,747,400.00	-252,600.00	94.95
210604	Урсгал засвар	8,322,700.00	5,798,000.00	-2,524,700.00	69.66
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19,277,400.00</b>	<b>16,923,700.00</b>	<b>-2,353,700.00</b>	<b>87.79</b>
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	7,888,000.00	-112,000.00	98.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,277,400.00	9,035,700.00	-2,241,700.00	80.12
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>115,747,100.00</b>	<b>108,673,421.00</b>	<b>-7,073,679.00</b>	<b>93.89</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,031,300.00	106,281,390.00	-5,749,910.00	94.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00	-432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,334,800.00	1,334,775.00	-25.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	905,000.00	422,556.00	-482,444.00	46.69
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	590,700.00	-409,300.00	59.07
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>8,981,850.00</b>	<b>-1,018,150.00</b>	<b>89.82</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	8,981,850.00	-1,018,150.00	89.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>192,665,200.00</b>	<b>192,665,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>185,000,000.00</b>	<b>185,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	185,000,000.00	185,000,000.00	0.00	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,665,200.00</b>	<b>7,665,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,665,200.00	7,665,200.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>590,502,400.00</b>	<b>577,279,571.00</b>	<b>-13,222,829.00</b>	<b>97.76</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>590,502,400.00</b>	<b>577,279,571.00</b>	<b>-13,222,829.00</b>	<b>97.76</b>
320001	Орон нутгийн төсвөөс	590,502,400.00	577,279,571.00	-13,222,829.00	97.76
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>15.00</b>	<b>21.00</b>	<b>6.00</b>	<b>140.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>10.00</b>	<b>3.00</b>	<b>142.86</b>
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	5.00	1.00	125.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	3.00	2.00	300.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>7.00</b>	<b>10.00</b>	<b>3.00</b>	<b>142.86</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	6.00	1.00	120.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	3.00	2.00	300.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,683,514,350.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,683,514,350.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	514,350.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	189,350.00
210104	Урамшуулал	189,350.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	265,000.00
210402	Тээвэр, шатахуун	265,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	60,000.00
210702	Дотоод албан томилолт	60,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,683,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,683,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,683,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1683514350.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,683,514,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,683,514,350.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид ИТХ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэл, төлбөрийн цахим баримт болон зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурлын зохион байгуулалт үйл ажиллагааг сайжруулах,
- Хурлын болон тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, бодлого зорилтыг тодорхойлох,
- Хууль, тогтоомж хурлын болон тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн биелэлтийн явцыг хянан шалгах, үр дүнг тооцох ажлыг сайжруулах,
- Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэх,
- Аймаг, сумдын эдийн засаг, санхүүгийн чадавхыг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх,
- Эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлж иргэдийн амьжиргааны чадавхыг дээшлүүлэх,
- Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжүүлэх бодлого зорилтыг тодорхойлж бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хүртээмж чанарыг сайжруулах,
- Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг, дэвшилтэд технологи, тэнцвэртэй харьцаа, зөв зохицлоор эрчимтэй хөгжүүлэх,

- Байгаль, орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдол, доройтлыг бууруулах, зохистой ашиглах,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах ажлыг эрчимжүүлэн, иргэдийн амгалан тайван, аюулгүй ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөө муутай** гэж үзэж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,268,058.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 22,680.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **15,876.4** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

ИТХ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,440.7 мянган төгрөгөөр буюу 29.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	36,740.5	32,393.7	(4,346.8)
Үндсэн хөрөнгө	64,458.3	39,364.4	(25,093.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>101,198.8</b>	<b>71,758.1</b>	<b>(29,440.7)</b>
Өр төлбөр	491.8	1,610.6	1,118.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	100,707.0	70,147.5	(30,559.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>101,198.8</b>	<b>71,758.1</b>	<b>(29,440.7)</b>

Бараа материалын данс 32,393.7 мянган төгрөг болж 4,346.8 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй 148.0 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 73,082.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 5,811.6 мянган төгрөгийн бараа материал актлан, үйл ажиллагаанд 71,765.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 243,209.6 мянган төгрөг болж өмнөх оноос 4,747.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,747.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,610.6 мянган төгрөг болж 1,118.8 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн 965.5 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 645.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 70,147.5 мянган төгрөг болж 30,559.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,546,381.4 мянган төгрөгөөр буюу 68.3 хувиар буурсан нь нэмэлт санхүүжилтийн орлого 1,545,956.4 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,520,931.4 мянган төгрөгөөр буюу 67.1 хувиар буурсан байна. Энэ нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд олгох нөхөн олговрын зардал 1,563,000.0 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 712,286.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж хүргүүлснийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 59,876.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 13,884.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 22,977.3 мянган төгрөгөөр, бусад зардлыг 25,046.9 мянган төгрөгөөр зэрэг нийт 121,784.4 мянган төгрөгөөр бууруулж, 590,502.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг хөтөлбөрийн 7 арга хэмжээний **590,502.4** мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 577,279.6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд **577,279.6** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Цагаатгалын улсын комиссоос 120,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 11,400.0 мянган төгрөг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын санхүүжилт 7,740.0 мянган төгрөг зэрэг нийт 139,140.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Цахим хэлбэрээр архивлах боломжтой “Аймгийн ИТХ-ын 2020 оны тогтоол, шийдвэрийн эмхэтгэл” / 500 ширхэг, нэг бүрийн үнэ 11,160.0 мянган төгрөг, “ Хууль, дүрэм, журмын эмхэтгэл” /300 ширхэг, нэг бүрийн үнэ 28,400.0 мянган төгрөг / зэрэг хууль, эрх зүйн актуудыг хэвлэн гаргахад нийт **14,100.0** мянган төгрөгийн зардал гаргасан байна. Цаашид хууль, эрх зүйн эмхэтгэлийг бодит хэрэгцээнд тохируулж цөөн тоогоор хэвлүүлэх, цахим хэлбэрээр архив үүсгэх зэргээр төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах нь зүйтэй юм.
- Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг тус аймагт албан ажлаар ажиллаж буй УИХ-ын гишүүд болон бусад албан хаагчид зэрэг дотоодын зочид төлөөлөгч хүлээн авах, унаа хоол, байр бэлдэх, бэлэг дурсгалын зүйлд зарцуулж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “код 210703: Зочин төлөөлөгч хүлээн авах: МУ-д гадаад улс орнуудаас албан ажлын айлчлалаар ирэх зочин, төлөөлөгч, ... айлчлахтай холбоотойгоор гарах зочид буудал, хоол унаа, бэлэг дурсгалын эд зүйлс бэлтгэх зардал” гэсэн заалтыг зөрчиж байна. Иймд зочин төлөөлөгч хүлээн авах зардлын зүйлд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай байна.
- ИТХ-ын дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Б. Нарантуяагийн 4 удаагийн захирамжаар хуралдааны болон зочид төлөөлөгч хүлээн авах зардлын /гадаад зочид төлөөлөгчдийн зардлыг санхүүжүүлэх зорилго бүхий/ батлагдсан төсвөөс ойн үйл ажиллагааны бэлэг дурсгалын зүйл худалдан авах, Улаанбаатар хотоос тус аймагт ажиллаж буй албан хаагчдын хоол, зочид буудлын зардал зэрэг зориулалт бус зардалд нийт 11,182.3 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж байна. Цаашид төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамж, шийдвэрийг хууль, эрх зүйн актад нийцүүлэн гаргах нь зүйтэй юм.

### 3.8 Аудитын гол асуудал

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 965.5 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 645.1 мянган төгрөгийн зэрэг нийт **1,610.6** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **14,368.7** мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 98 мэдээллийг хугацаанд нь **50** мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн бол **3** мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант оны үйл ажиллагаанд 590,502.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 577,279.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **2.2** хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 5,787.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,275.0 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлж **6,780.4** мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	5,787.8	2	5,787.8	100.0
Албан шаардлага	5	11,055.4	1	4,275.0	20.0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>16,843.2</b>	<b>3</b>	<b>10,062.8</b>	<b>42.8</b>

Өмнөх аудитаар өгсөн батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, өр төлбөр үүсгэсэн, шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу холбогдох албан тушаалтанд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88,556.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 965.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,979.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 71,611.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Тайлант оны НДШ-ийн тайланд 10 албан хаагчийн 4,096.8 мянган төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тайлагнаагүй болон **965.5** мянган төгрөгийн өр төлбөр үүссэнийг санхүүгийн тайланд залруулав.

### 4.2 Албан шаардлага:

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 965.5 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 645.1 мянган төгрөгийн зэрэг нийт **1,610.6** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зохистой удирдах буюу төлбөр тооцоог урьдчилан хянасны улмаас өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн өр төлбөрийг 2022 онд нөхөн тооцож, барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Дараах хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **14,368.7** мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөл, хороо, комиссын гишүүд, ангилагдаагүй бусад зориулалт зэрэг хөтөлбөрийн НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардалд **760.7** мянган төгрөг,
- ИТХ-ын хуралдааны зардалд баталсан хоолны зардлаас УИХ-ын гишүүд, сэтгүүлчдийн хоол, зочид буудлын зардалд **480.4** мянган төгрөг,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардлаас дотоодын зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 447.0 мянган төгрөг, хоолны зардалд 239.3 мянган төгрөг зэрэг нийт **686.3** мянган төгрөг,

- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд **438.8** мянган төгрөг,
- Баяр наадмын арга хэмжээний */Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн аяга, бал, дэвтэр гэх мэт бэлэг дурсгалын зүйл/, зардалд зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 7,580.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 3,363.0 мянган төгрөг зэрэг нийт **10,943,0** мянган төгрөг,*
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал болон хуралдааны зардлаас бусдад өгөх бэлэг гэх үндэслэлээр **531.5** мянган төгрөгийн архи, **528.0** мянган төгрөгийн */9 сард/* чихэр зэргийг худалдан авсан байна. */Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нээж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн/*

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

**3. Шилэн дансны цахим хуудсанд 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бөгөөд худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан бүтэн жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэрэг 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.**

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Тус газрын албан хэрэгцээнд ашиглаж буй 2 авто машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд 5,568.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд Өмч хамгаалах зөвлөлөөр засварлуулах машины эвдрэл гэмтэл, шаардлагатай сэлбэг хэрэгсэл, эд ангийн талаарх мэдээллийг авч хэлэлцэж шийдвэрлээгүй, өөрөөр хэлбэл анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Машины эвдрэл гэмтлийг анхан шатны баримтаар нотлох, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд тавих хяналтыг сайжруулах.

##### **2. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 66,043.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж Цаашид төлбөрийн цахим баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	5	88,556.4	1	965.5	-	-	2	15,979.3	2	71,611.6